

Баглалт IOI 95

Дөрвөн тэгш өнцөгт өгөгджээ. Тэгвэл энэ дөрвөн тэгш өнцөгтийг давхарлахгүйгээр хамгийн бага талбайтай тэгш өнцөгт хэлбэртэй хайрцганд багла.

Бүх тэгш өнцөгтийн талууд хайрцагнахаа талуудтай паралель байна. Зураг 1-т 6 янзаар дөрвөн тэгш өнцөгтийг байрлуулж үзүүлсэн байна. Энэ зургаан байрлуулалт нь боломжтой байрлалууд ба байрлуулахдаа дүрсийг 90 градусаар эргүүлж болно.

Магадгүй хамгийн бага талбайтай хайрцаг олон байна. Тийм бол бүх хариуг гарга.

Оролт

Тэгш өнцөгтүүдийн урт өргөнийг илэрхийлэх 4 мөр байна. Дөрвөн өнцөгтийн аль нэг тал хамгийн ихдээ 50 байна.

Гаралт

Гаралт нь шийдийн тооноос хамаарсан нэг ба түүнээс дээш мөрийг агуулна. Эхний мөрөнд хамгийн бага талбайтай тэгш өнцөгтийн талбайг илэрхийлсэн тоо. Дараагийн мөрүүдэд хайрцагны талуудын уртыг илэрхийлсэн p ба q тоонууд $p \leq q$ байхаар эрэмбэлэгдэн байрлана.

Жишээ

Оролт :

1 2

2 3

3 4

4 5

Гаралт :

40

4 10

5 8

Орчуулсан : Б.Батбаатар